

Living the Lotus 9

Buddhism in Everyday Life

2023

VOL. 216



РКК Тайнэй нийгэмлэг

Living the Lotus Vol. 216 (2023.09)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami
-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туульгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Шунал бол зовлонгийн үндэс

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Шунамхай сэтгэлээс үүдэх гай тоггор

Хятадын яруу найрагч Ду Шэньян нь (645–708) намрын улиралыг “тэнгэр цэлмэг цаг агаар тогтуун, мал сүрэг таргална” хэмээн шүлэглэсэн байдаг. Харин Японд намрыг хоолны дуршил нэмэгддэг улирал гэж үздэг. Зуны халуун өнгөрөхөд хоолны дуршил нэмэгдэж юуг ч амтархан идэж болдог улирал тул үнэхээр талархалтай. Гэхдээ хэтрүүлэн идээд, дараа нь харамсахгүйн тулд хэмжээг нь тааруулан идэх тал дээр анхаарууштай.

Хоолны дуршил нэмэгдэж, жаахан жин нэмсэн бол идэх хэмжээгээ багасгахад асуудлаа шийдэж болно. Харин Шагжамүни бурхан “төрөл бүрийн зүйлсийг шунамхайран хүсэхэд олон сэтгэлийн гэм (нисваанис)-д ялагдаж, аюулт гамшиг түүнийг гишгэн түрэмгийлдэг” гэж хэлээд, шунах тусам шуналын харанхуй хэрхэн бие сэтгэлд хохирол учруулдаг тухай сургасан байдаг. Энд дурдагдах шунал хэтэрвэл “аюултай гамшиг”-т гишгүүлэн дарагдана гэсэн хэсэг огтхон ч жижиг асуудал биш юм.

“Тариан талбай, гэр орон, эхнэр болон хамаатан садан, бусад төрөл бүрийн зүйлсийг шунан хүсвэл” гэсэн Нипата судрын нэг мөртөөс харахад, мөнгө, эд хөрөнгийг хүсэмжлэх хэт их шунал нь өөрийн болон бусдын үзэн ядалт, уур бухимдал, атаа жөтөөг төрүүлж, эдгээр шалтгааны улмаас гай гамшиг гэдэг асуудал буун ирдэг гэсэн утгыг илэрхийлж байгаа болов уу. Эсвэл “шуналтай хүн шүү” гэж бусдад адлуулах, бусдын хэл амнаас үүдэлтэй стресс нь биед муу нөлөө үзүүлэх боломжтой.

Шагжамүни бурхан “шуналд автсан хүний хүсэл нь биелэхгүй бол суманд оногдсон адил шаналан зовдог” гэж хэлсэн байдаг. Бурхан багш энэ үгийг зүгээр ч нэг хэлээгүй, эргэн тойронд нь шуналаасаа болон зовж байгаа хүнийг бодитоор харж, сонссон туршлага дээрээ үндэслэн хэлсэн болов уу. Мөн хэтэрхий их шунаснаасаа болоод хүмүүстэй байнга муудалцаж, заримдаа хүч хэрэглэн тэднийг гэмтээх хүн бурхан багшийн ойролцоо байсан байж магадгүй. Аливаа зүйлийг хэт шунан хүсэж буй хүн эрүүл саруул амьдралаас хол, зовлон шаналалыг тээж байгаа гэдгийг Шагжамүни бурхан мэдэрч чадсан байна.

Нийгмийн амьтан гэгддэг хүн төрөлхтөний хэрэгцээнээс илүү шунадаггүй бусад амьтдаас ялгарах тал нь заримдаа өөрсдийн шуналаа зогсоож чаддаггүй байх явдал юм. Тийм ч учраас бусдад туслах сэтгэлийг марталгүй шуналаа зохистой түвшинд барихыг хичээх нь орхигдуулж боломгүй чухал зүйл билээ.

Байгаа зүйдээ сэтгэл ханахын жаргал

Хүн төрөлхтөний шунал хүслийг зөвхөн муу талаас нь харж болохгүй. Шагжамүни бурхан “бүх хүнийг аврахсан” гэсэн агуу хүслийг тээж, энэрэл нигүүлсэл болон бусдын төлөө гэсэн сэтгэлээс улбаатай тэрхүү хүслийнхээ араас явсаар бүгдийг аз жаргалтай болгох үнэн хуулийг гэгээрсэн билээ. Мэдээж Шагжамүни бурхантай ижил хүсэл хүмүүс бидний дотор ч байгаа бөгөөд энэ нь хүн төрөлхтөний хөгжил, дэвшилтийн эх үндэс болсоор ирсэн.

Гэхдээ хүслээ хянаж чадахгүй болвол “сэтгэлийн гэм буюу нисваанис” болон хувирч, бидний шаналган зовоох үндэс болдог. Санаснаар болохгүй бол зовж, өөрийн сэтгэлээ дүүргэхийн тулд тэнцвэртэй харж чадахаа байж, хүн хоорондын харилцаагаа сүйтгэх зэргээр илүү зовлонг өөртөө дуудаж орхидог. Ийм зүйлтэй учрахгүйн тул бурханы сургаалд “бага хүсч ханахыг мэд”-хүсэл шуналаа дарж, хүрэлцэх ханахыг мэдэх- ийн чухлыг сургасан байна. Хэрэв энэ сургаалыг хэрэгжүүлж чадвал шуналаас болж амсах бие сэтгэлийн хор хөнөөлөөс сэргийлж чадах боловч, мэдсээр байж чаддаггүй нь бидний сул тал.

Та бүхэнд “бага хүсч ханахыг мэд” сургаалын “бага” гэдэг үгийг “жижиг” гэсэн үгээр сольсон сургаалын тухай тайлбарля. Ингэж үгийг солиход тийм том ялгаа гарахгүй боловч эртний пали хэлэнд дээрх сургаалыг “хэрэгцээг хангахуйц хэмжээтэй байгаад баярлах” гэсэн утгатай гэж үздэг. Хятадад буддын шашны нөлөөг түгээгч Хуан Зан (602-664он) нь “ханахыг мэдэх” гэдэг үгийг гүнзгийрүүлэн хүлээн авч “ханахын жаргал” гэж орлуулан хэлээд, сэтгэл ханахыг мэдэх нь жаргал юм хэмээн дамжуулсан байдаг. Хэрэгцээг хангахуйц хүсэл биелэх нь аз жаргал юм гэдгийг мэдвэл сэтгэл ханах баяр хөөрийг амтлахын тулд аяндаа хүсэл шуналаа дарж чадах болов уу. Түүнчлэн ханахыг мэддэг байх хэрэгтэй хэмээн сургамжлахаас илүү дээрх үг хүмүүст энгийн ойлгомжтой, өөрийгөө хүчлэлгүйгээр хүсэл шуналаа хянаж сурахад нөлөөлөх болов уу.

Хэрэгцээ хангагдах хэмжээнд баярлаж чаддаг байх шиг эрүүл саруул болоод аз жаргалтай амьдрал байхгүй болов уу гэж би бодно.

<Косей> 2023 оны 9-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Юмс үзэгдлийн жинхэнэ дүр төрх

Цагаан лянхуа судар нь энэ ертөнцийн бүхий л зүйлсийн жинхэнэ дүр төрхийг олж харахын чухлыг сургадаг. Энэхүү “аливаа зүйлийн жинхэнэ дүр төрх” гэдэг нь “Юмсын жинхэнэ бодит байдал”-ыг хэлж буй юм.

Бид янз бүрийн үйл явдал тохиолдоход өөрийн бодолдоо тулгуурлан дүгнэлт шийдвэр гаргадаг.

Жишээлбэл, замаар алхаж явахад том чулуу унасан байвал ихэнх хүмүүс “замын саад юмаа” гэж бодох байх.

Гэвч үүнийг чулууны үүднээс авч үзвэл, чулуу зөвхөн чулууныхаа хувиар тэнд оршин байгаа ба хүмүүсийг зовоож гамшиг авчирья гэж байгаа зүйл биш билээ. Өөрөөр хэлбэл “замын саад” гэж үзэж байгаа нь зөвхөн бидний л юмыг харж байгаа байдал юм.

Ийм байдлаар бид өөрсдийн өрөөсгөл ойлголт, дуртай дургүй гэдэгтээ үндэслэн аливаа зүйлийг дүгнэх хандлагатай байдаг. Юмс үзэгдлийг ингэж авч үзвэл түүний жинхэнэ дүр төрхийг харж чадахгүй юм.

Тиймээс аливаа зүйлсийн жинхэнэ дүр төрхийг харахын тулд хүн, юмс үзэгдлийг байгаагаар нь хүлээж авах нь чухал гэж Цагаан лянхуа сударт номлодог.



Бяцхан мэдлэг

Юмсын жинхэнэ дүр төрх гэсэн утгатай “Шёхо” хэмээх ханз нь бүх юмс үзэгдэл, “Жиссо” гэдэг нь жинхэнэ төрх байдал гэсэн утгатай. Цагаан лянхуа сударт зөвхөн Будда л бүхий л зүйлсийн бодит байдлыг харж чадна гэж заасан бөгөөд аливаа зүйлийг өөрсдийн өрөөсгөл бодлоор харахгүй байх нь чухал гэж сургадаг.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Гурван тэрэг ба шатсан байшингийн үлгэр



Цагаан лянхуа сударт 7 зүйрлэл үлгэр гардаг бөгөөд эдгээрийг нэгтгээд судрын 7 үлгэр гэдэг.

“Судрын 7 үлгэр”-т Цагаан лянхуа судрын хэцүү сургаалыг үлгэрээр дамжуулан хялбараар тайлбарласан бөгөөд хамгийн эхнийх нь “Гурван тэрэг ба шатсан байшин”-гийн үлгэр юм.

Нэг улсад нэгэн баян ноёны хуучирсан эзэнгүй байшин байжээ. Тэр байшинд гал гарчээ. Дотор нь хүүхдүүд гал авалцаж буйг анзааралгүй тоглож байлаа. Гадаа байсан гэрийн эзэн ноён анхааруулан хашгирсан боловч анзаарсангүй.

Тэгээд ноён хүүхдүүдийн үргэлж хүсдэг байсан хонин тэрэг, үхэр тэрэг, гөрөөсөн тэрэг байшингийн гадаа байна гэж хашгирав. Үүнийг сонсоод хүүхдүүд шатаж буй байшингаас амжиж гарч иржээ. Хүүхдүүдийг эсэн мэнд байгаад баярласан ноён хүсч байснаас нь ч илүү их цагаан үхэр тэрэг тэдэнд бэлэглэсэн тухай үлгэр юм.

Баян эр бол Будда, хүүхдүүд нь бид, хуучирсан байшин бол бидний зууралдсан энэхүү ертөнц, гал түймэр нь бүхий л зовлон, тэрэгнүүд нь тус

бүр нэг төрлийн сургаалыг илэрхийлж буй. Энэхүү сургаалт зүйрлэл нь хүсэл шуналдаа автамтай биднийг энэхүү ертөнцөд чадварлаг удирдан чиглүүлдэг Буддагийн мэргэн ухаан, энэрэнгүй сэтгэлийг өгүүлсэн үлгэр юм.

Бяцхан мэдлэг

Гурван тэрэг нь хонин тэрэг, гөрөөсөн тэрэг, үхэр тэрэг бөгөөд брадигабудда, ширваган, бодьсадва гэсэн Будда болох гурван зам мөрийг илэрхийлсэн байна. Бурхан энэхүү 3 зам мөрийн алийг нь ч дагасан бай хамгийн дээд сургаал болох “их цагаан үхэр тэрэг”-ийг өгдөг гэсэн энэхүү түүхийг “Цагаан лянхуа” судрын “үлгэрлэл” гуравдугаар бүлэгт өгүүлдэг.



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК, удаах ерөнхийлөгч
Нивано Коошоо

Үүсгэн байгуулагч ба жижигхэн хүмүүс

Жаахан хүүхэд залуухан ах, эгч нарт дуртай байдаг. Олон хүнтэй газар очлоо гэхэд яаж ийж байгаад л хамгийн залуу хүнийг олоод дэргэд нь оччихсон явж байдаг. Манай гэрийн хүүхдүүд ч ялгаагүй. Гэсэн хэдий ч үүсгэн байгуулагчийн хувьд ондоо байлаа.

Үүсгэн байгуулагч том охиныг маань төрөхөд “том жич охин” хэмээн их баярласан. Үүсгэн байгуулагч, том охин маань яг 90 насны зөрүүтэй байсан боловч охин маань үүсгэн байгуулагчид маш их хайртай байсан юм.

Хүүхдээ төрүүлэхээр төрсөн гэртээ буцаж ирсэн би охиныгоо 5 сартай болоход нь нөхрийнхөө сурч байсан Ром луу буцав. Гадаадад анхны хүүхдээ өсгөхөд амаргүй байсан. Охин маань хоолондоо муу байсан нь юу юунаас илүү санааг минь зовоодог байлаа. Байдгаараа хичээж бор хоолонд оруулах гэсэн боловч хийсэн хоолыг маань барагтай иддэггүй байв.

Нэг жилийн дараа ой хагастай болсон охиноо дагуулаад Япон луу амралтаараа очив. Эргэн тойрны хүмүүс охиныг минь хараад “ямар туранхай юм бэ”, “аав ээж нь өөрсдөө хоолоо баяр хөөртэй иддэггүй болохоор хүүхэд нь хоолонд дургүй болдог” гэх зэргээр хэлж, миний сэтгэлийг эмзэглүүлэв.

Тэр үед үүсгэн байгуулагч нэлээд өндөр настай болсон байсан тул багагүй турж, эмчийн зүгээс хоолны хэмжээгээ ихэсгэ гэсэн анхааруулга авсан байлаа. Нэг удаа үүсгэн байгуулагч том охинд маань хандан “өвөө нь ч гэсэн хичээн идэх болноо, хамтдаа хоолоо сайн идэхийг хичээе” гэж уриалав. “Хөөрхөн дагуултай боллоо” гээд баярлаж, тэр өдрөөс хойш том охин маань үүсгэн байгуулагчийн хажууд суугаад хамтдаа хооллох болов.

Ром луу буцаж очсон ч “өвөө нь хичээгээд идэж байгаа шүү” гэсэн үүсгэн байгуулагчийн дүрс бичлэгийг хүлээн авч, охиныгоо хоолоо сайн идэхгүй үед үзүүлэхэд гайхалтай нь бичлэг үзсэний дараа хоолоо сайн иддэг байв.

Дараа жил нь харих үед 2 настай болсон охин маань хоолны дараа өвөөгөө босох гэхэд нь түрүүлж гүйж очоод, жижигхэн гараараа өвөөгийнхөө гараас татаад, өрөөнийх нь хаалгыг онгойлгож, үүсгэн байгуулагчийг хаа явсан газарт араас нь дагах болов. Шүдээ угаах хооронд хүртэл ард нь зогсоод хараад зогсчихдог байв. Өвөөдөө үнэхээр хайртай юм байна даа гэж бодогддог байв.

Дараа жил нь 3 настай болсон том охин, Ромд мэндэлсэн 6 сартай хоёр дахь охиноо дагуулаад нутаг руугаа явав. Онгоцны буудлаас шууд үүсгэн байгуулагчийн хэвтэж байгаа Косей эмнэлэг лүү хөдлөв. Үүсгэн байгуулагчийг байгаа дээр нь шинэхэн мэндэлсэн охиноо уулзуулахгүй бол дараа нь харамсана гэж бодсон тул 15 цагийн урт онгоцны аялалын дараа шууд эмнэлэг рүү хөдөлсөн нь тэр байлаа. Охидууд маань урт аялал, цагийн ялгаанаас болоод ядраад машин дотор унтсан байлаа. Сэрээвэл дургүйцэх байхдаа хэмээн бодоод, унтсан чигт нь тэврээд



Нивано Коошоо

Рисшо Косей Кай байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуульч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараа тус байгууллагын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Судрыг судлан суралцахын хажуугаар гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтрах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн тус байгууллагын удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

нөхөртэйгөө цуг үүсгэн байгуулагчийн хэвтэж байгаа өрөөнд оров.

Эмч, сувилагч, нарийн бичиг, зурагчин, зураглаач гэх зэрэг олон хүнээр хүрээлүүлсэн өрөөнд нүдээ нээсэн охин маань нүдээ нухлангаа “үүсгэн байгуулагчаа бид хариад ирлээ” гэж мэндлэв. “Манай гэрийн шинэ гишүүн” хэмээн би тэвэрч байсан удаах охиноо танилцуулахад үүсгэн байгуулагч “гийм байна, сайн яваад ирэв үү” гээд над руу гараа сунгав. Тэгэхэд яг тэр мөчид нүдээ нээн сэрсэн зургаахан сартай охин маань уйлах ч үгүй, анх удаа харж байгаа үүсгэн байгуулагч руу биеэ сунгаж, гар гараасаа барьсныг би одоо хүртэл маш сайн санадаг.

Тэр явдлаас хойш ойролцоогоор 2 сарын дараа 10-р сарын 3 ны өдөр нөхөр маань Ром руу дараа өдрийн өглөө түрүүлээд буцах болсон тул үүсгэн байгуулагчтай мэнд мэдэхээр эмнэлэг явсан тул би бас дагаад явав. Үүсгэн байгуулагч унтаж байсан тул асарч байсан манай ээж, бид хэд хажууд нь хэсэг чимээгүй зогсов. Нүдээ нээсэн үүсгэн байгуулагчтай мэндлээд бид харьсан юм. Энэ нь үүсгэн байгуулагчтай өнгөрүүлсэн сүүлийн мөч байсан юм.

“Якүшин” 2010 оны 9-р сарын дугаараас

Олон улсын хэлтсийн даргын булан



Хүсэл шуналыг хязгаарлах нь

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу?

Нивано ерөнхийлөгч энэ сарын айлдвараараа бидний хэн бүхэнд байдаг “Шунал хүсэл”-ийн талаарх асуудлыг хөндлөө.

Миний бодлоор "шунал" гэдэг нь түүнтэй яаж харьцаж байгаагаас шалтгаалаад ашиг тустай эсвэл хор хөнөөлтэй байж болох ч "шуналын арьс сунасаар байдаг" гэдэг үгэнд гардагчлан хяналтаас гарвал "гай тотгор", "зовлон"-гийн шалтгаан болдог жишээтэй хүн бүр тулгарч байсан болов уу.

Айлдварт "хүсэл шунал бага байсан ч ханаж цадахыг ойлгох", "багахан хүсэлд сэтгэл ханах" зэрэг маш сонирхолтой үгсийг тайлбарлаж оруулжээ. "Ханахыг мэдэхийн баяр баясгалан"-г мэдэрч чадвал хүмүүс амьдралдаа ямар их сэтгэл дүүрэн байх болоо. Энэ мэдрэмжийг өдөр тутмын амьдралдаа мэдрэх хүсэл надад өөрийн эрхгүй төрсөн. Би Косэй Кай нийгэмлэгтэй учирсанаар Үүсгэн байгуулагч, Нивано ерөнхийлөгч зэрэг амьдралынхаа багш нартай уулзсандаа талархаж явдаг. Цагаан лянхуа судрын сургаалаар дамжуулан би буддын шашны гүн гүнзгий утгад бага багаар ойртож, номын андуудтайгаа бодит амьдрал дээрх буяны үйлийн баяр хөөрийг дахин дахин мэдрэхийг хүссэн айлдвар байлаа.

Шагжамүни бурхны “Буддагийн арван цол”-онд Буддагийн ач буяныг илтгэсэн “Зам мөрт хөтлөх уран аргатай хүн” хэмээх хүндтэй цол бий. Би өглөг буяны сэтгэлийг маргалгүй, өөрийн хүсэл шуналаа дарж, өдөр бүр хичээнгүйлэн бурхны үйлд шамдая гэж бодож байна.




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers

facebook

twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp